



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/13

Хэрлэн сум

Тусгай зөвшөөрөл сунгах, ажлын
байрны байршил өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5, Эрүүл мэндийн сайдын “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах журам”-ын 2.6.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 53 дугаар тогтоолын 5.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын 2023 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан байгууллагын нэрсийг нэгдүгээр, үйл ажиллагаа явуулж буй ажлын байрны байршил өөрчилсөн байгууллагын нэрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрх байгууллагуудын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн Эмийн чанар, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн /О.Энх-Уянга/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга /Д.Наранмичид/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Х.ДОРЖХАНД



Эрүүл мэндийн газрын
даргын 2023 оны.... дугаар сарын
..... өдрийнтоот тушаалын нэгдүгээр
хавсралт

**Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай
зөвшөөрлийн хугацааг сунгасан байгууллагуудын нэрс**

№	Тусгай зөвшөөрөл эзэмшиж буй байгууллагын нэр	Тусгай зөвшөөрөл сунгасан хугацаа	Хүчинтэй хугацаа
1	Баянмөнх сумын “Мөнхрөх Гэрэлт Тун” ХХК-ийн эмийн сан	1 жил	2023.05.05-2024.05.05
2	Цэнхэрмандал сумын “Өргөнбаян Хангай” ХХК-ийн эмийн сан	1 жил	2023.05.05-2024.05.05
3	Өмнөдэлгэр сумын “Далерон” ХХК-ийн эмийн сан	3 жил	2023.05.05-2026.05.05
4	Биндэр сумын “Биндэр Амгалант Эрдэнэ” ХХК-ийн эмийн сан	3 жил	2023.05.05-2026.05.05
5	Баян-Овоо сумын “Гүрэм Оюут” ХХК-ийн эмийн сан	3 жил	2023.05.05-2026.05.05
6	Хэрлэн сумын “Хэнтий Хэрлэн” ХХК-ийн “Арвад шагай” эмийн сан	3 жил	2023.05.10-2026.05.10
7	Хэрлэн сумын “Ариун Аз” ХХК- ийн ахуйн шавж мэрэгч устгах, халдваргүйжүүлэх байгууллага	5 жил	2023.05.27-2028.05.27

Эрүүл мэндийн газрын
даргын 2023 оны.... дугаар сарын
..... өдрийнтоот тушаалын хоёрдугаар
хавсралт

**Үйл ажиллагаа явуулж буй ажлын байрны
байршил өөрчлөгдсөн байгууллага**

№	Тусгай зөвшөөрөл эзэмшиж буй байгууллагын нэр	Өөрчлөгдсөн байршил
1	Батноров сум "Болор Тайван" ХХК-ийн "Причал" эмийн сан	Батноров сум 6 дугаар баг Лосолын гудамж 203-2 тоот